



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 351

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны 422 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 6 нэрийн (багц) нийт 2,570,217,944.60 (хоёр тэрбум таван зуун далан сая хоёр зуун арван долоон мянга есөн зуун дөчин дөрвөн төгрөг жаран мөнгө) төгрөгийн балансын үнэ, 2,203,043,952.51 (хоёр тэрбум хоёр зуун гурван сая дөчин гурван мянга есөн зуун тавин хоёр төгрөг тавин нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Хөдөө аж ахуйг дэмжих санд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Т.Жамбалцэрэн, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн захирал Б.Батцэцэг, Хөдөө аж ахуйг дэмжих сангийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Батбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 01 дугаар сарын 06-ны өдрийн  
357 дугаар тогтоолын хавсралт

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ХӨДӨӨ ӨЖ АХУЙГ ДЭМЖИХ САНД БАЛАНСААС  
БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д      | Хөрөнгийн нэр                               | Ашиглалтанд<br>орсон он | Хэмжих<br>нэгж | Тоо<br>хэмжээ | Нэг бүрийн үнэ<br>(төгрөг) | Балансын үнэ<br>(төгрөг)                                                                                                       | Хуримтлагдсан<br>элэгдэл (төгрөг)                                                                                     | Үлдэгдэл өртөг<br>(төгрөг)                                                                                         |
|----------|---------------------------------------------|-------------------------|----------------|---------------|----------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1        | Өвс хаман боогч машин                       | 2014.01.01              | ш              | 28.00         | 24,875,000.00              | 696,500,000.00                                                                                                                 | 597,000,000.00                                                                                                        | 99,500,000.00                                                                                                      |
| 2        | Ногоон тэжээлийн үйлдвэр                    | 2014.01.01              | ш              | 4.00          | 33,333,333.00              | 133,333,332.00                                                                                                                 | 114,285,713.14                                                                                                        | 19,047,618.86                                                                                                      |
| 3        | Хадлан бэлтгэлийн иж<br>бүрдэл              | 2014.01.01              | ш              | 24.00         | 53,300,000.00              | 1,279,200,000.00                                                                                                               | 1,096,457,142.86                                                                                                      | 182,742,857.14                                                                                                     |
| 4        | Малын тэжээлийн<br>үйлдвэрийн иж бүрдэл 201 | 2014.01.01              | ш              | 5.00          | 17,923,076.92              | 89,615,384.60                                                                                                                  | 76,813,186.80                                                                                                         | 12,802,197.80                                                                                                      |
| 5        | Малын тэжээлийн<br>үйлдвэрийн иж бүрдэл     | 2014.01.01              | ш              | 3.00          | 17,923,076.00              | 53,769,228.00                                                                                                                  | 46,087,909.72                                                                                                         | 7,681,318.28                                                                                                       |
| 6        | Хүчит тэжээлийн үйлдвэр                     | 2014.01.01              | ш              | 14.00         | 22,700,000.00              | 317,800,000.00                                                                                                                 | 272,399,999.99                                                                                                        | 45,400,000.01                                                                                                      |
| Нийт дүн |                                             |                         |                |               |                            | 2,570,217,944.60                                                                                                               | 2,203,043,952.51                                                                                                      | 367,173,992.09                                                                                                     |
|          |                                             |                         |                |               |                            | (хоёр тэрбум<br>таван зуун далан<br>сая хоёр зуун<br>арван долоон<br>мянга есөн зуун<br>дөчин дөрвөн<br>төгрөг жаран<br>мөнгө) | (хоёр тэрбум<br>хоёр зуун гурван<br>сая дөчин гурван<br>мянга есөн зуун<br>тавин хоёр төгрөг<br>тавин нэгэн<br>мөнгө) | (гурван зуун<br>жаран долоон<br>сая нэг зуун<br>далан гурван<br>мянга есөн зуун<br>ерэн хоёр төгрөг<br>есөн мөнгө) |